



HEPCLUDEX®

Bulevirtid 2mg


Pulver zur Herstellung einer Injektionslösung



Mongolisch

Тарилгын зааварчилгаа

AT-HPX-0083; 09/2023



Gilead Sciences GesmbH
Wagramer Straße 19
1220 Wien



GILEAD

Creating Possible

Тарилга хийх алхам алхмаар зааварчилгаа

Энэхүү тарилгын зааварчилгыг эмчээс НЕРСЛУДЕХ® тарилгын жор бичүүлж авсан өвчтөнүүдэд зориулсан. Энэ нь өвчтөнд мэдээлэл өгөх товхимлыг орлохгүй боловч тариаг өдөр тутам аюулгүй тарихад танд туслах нэмэлт мэдээлэл болох юм. Өвчтөнд мэдээлэл өгөх товхимол/саван доторх зааврыг үргэлж анхааралтай уншина уу.


Та энэ тариагаар гэрийн нөхцөлд эмчилгээ эхлүүлэхийн өмнө таны эмч эсвэл сувилагч танд НЕРСЛУДЕХ® тариаг хэрхэн бэлтгэж, тарихыг харуулна. Энэхүү зааварчилгаа тариаг өөртөө хэрхэн тарихыг харуулдаг. Хэрэв танд ямар нэг зүйл тодорхой бус эсвэл асуулт байгаа, илүү мэдээлэл эсвэл тусламж хэрэгтэй бол эмч эсвэл сувилагчдаа хандана уу. НЕРСЛУДЕХ® тариаг бэлтгэж, тарихдаа анхааралтай байж, яарах хэрэггүй.

Тариа хийх газар



Тарилга хийх газар хариу урвал үүсэхийг багасгах үүднээс та НЕРСЛУДЕХ® тариаг хийх газрыг тогтмол өөрчилж болно.

НЕРСЛУДЕХ® тариаг дараах **газар хийж болохгүй**: өвдөг, цавь, өгзөгний доод хэсэг эсвэл дотор тал, судасны шууд дээгүүр, хүйсийн эргэн тойрон (хүйс), сорвижсон эд, цус хурсан газар, мэнгэ, мэс заслын сорви, шивээстэй эсвэл түлэгдсэн хэсэг, тарилга хийсэн газар хариу урвал үүссэн хэсэг.

Хэвлий




Гуяны дээд хэсэг



1A

Хадгалалт


НЕРСЛУДЕХ® туншлыг гэрлээс хамгаалахын тулд НЕРСЛУДЕХ® тариатай шилийг анхны саванд нь хөргөгчид (2–8 °C) температурт хадгалах ёстой.



1B

Найруулах тун


Нэг тунг найруулахад дараах зааварчилгааг дагана.



1C

Гараа угаах


Саван, бүлээн ус ашиглан гараа угаагаад, цэвэр алчуураар хатаана уу. Таны гар цэвэр болсны дараа тариа, түүний дагалдах хэрэгсэл, тарилга хийх газрын эргэн тойрноос бусад өөр юунд ч **хүрч болохгүй**.



1D

Туншлын тагийг цэвэрлэх

Тариатай шилний тагийг спирт шингээсэн шинэ хөвөнгөөр арчаад, дээд хэсгийг нь өрөөний температурт хатаана уу. Хэрэв та цэвэрлэсний дараа резинэн таганд хүрсэн бол спирт шингээсэн шинэ хөвөнгөөр дахин арчина уу.



2A

Ариутгасан усыг соруулах

Тариурыг авна уу. Урт зүүг хатгана уу.


Чухал! Хатгасан зүүг цагийн зүүний дагуу эргүүлэнгээ чанга оруулахын тулд доош нь бага зэрэг түлхэнэ үү. Хуванцар тагийг сугалж авна уу.

Тарилгад зориулсан ариутгасан усыг онгойлгоно. Зүүг шилэнд оруулаад, устай шилийг зөөлөн доош нь харуулна.

Хийн бөмбөлөг тариурт орохоос сэргийлж зүүний үзүүрийг үргэлж усны гадаргуугаас доош байлгана уу.

1.0 мл ариутгасан усыг тариурын соруураар аажмаар соруулж тариурт хийнэ үү.

Шилнээс зүү, тариурыг болгоомжтой салгана уу.




2B

Ариутгасан усыг нунтаг руу шахах

Нунтгийг уусгахын тулд HEPCLUDEX® тариатай шилийг зөөлөн тогшино уу.

Ариутгасан устай зүүг HEPCLUDEX® тариатай шилэнд өнцөгдөж оруулна уу.

Ариутгасан усыг HEPCLUDEX® нунтаг уруу шилний хажуугаар урсаж орохуйцаар аажмаар тарина уу.




2C

HEPCLUDEX® тариаг зөөлөн холих

Нунтгийг уусгаж эхлэхийн тулд HEPCLUDEX® тариатай шилийг хурууныхаа үзүүрээр 10 секунд зөөлөн тогшино уу. Дараа нь сайтар холих үүднээс HEPCLUDEX® тариатай шилийг хоёр гарынхаа хооронд зөөлөн үрнэ үү. Шилний хананд HEPCLUDEX® нунтаг үлдээж болохгүй.


Чухал! HEPCLUDEX® тариатай шилийг сэгсэрч болохгүй. Сэгсрэх нь тариаг хөөсрүүлж, уусахад илүү удаан хугацаа зарцуулагдана.



2D

HEPCLUDEX® тариаг шалгах

Нунтаг уусаж эхэлмэгц зүгээр орхих бөгөөд бүрэн уусах болно. Товшсоны дараа уусахад 3 хүртэл минут шаардагдаж болно.



2E

HEPCLUDEX® тариа тарихад бэлэн болсон

Бүрэн хольсны дараа HEPCLUDEX® уусмал тунгалаг байх ёстой.

Чухал! Бүрэн ууссан HEPCLUDEX® тариа тунгалаг бөгөөд хөөсрөөгүй байх ёстой. Хэрэв HEPCLUDEX® уусмал хөөсөрхөг эсвэл шаргалдуу өнгөтэй харагдвал уусгахын тулд дахиад хэсэг хүлээнэ үү.

Хэрэв танд бөмбөлөг харагдвал арилтал нь шилийг зөөлөн товшино уу.

Хэрэв HEPCLUDEX® уусмал ууссаны (бүрэн) дараа уусмал дотор ямар нэг биет харагдвал тухайн туншлыг ашиглаж болохгүй. Уг тариаг өгсөн эмч эсвэл эмчийн санчтайгаа холбоо барина уу.


Найруулсан булевиртидийг нэн даруй хэрэглэх ёстой.


2F

Шил цэвэрлэх

HEPCLUDEX® шилний дээд талыг шинэ спирттэй хөвөнгөөр дахин арчина.

Сэврээж хатаана.






3А

Шилэнд зүүг оруулах

Тариурыг авна уу.

HEPCLUDEX® шингэн бүхий туншилд зүүг оруулна уу




3В

HEPCLUDEX® тариаг соруулах

Шилийг зөөлнөөр доош нь эргүүлнэ үү. Хийн бөмбөлөг тариурт орохоос сэргийлж, зүүний үзүүрийг үргэлж HEPCLUDEX® уусмалын гадаргуугаас доош байлгана уу.

1.0 мл HEPCLUDEX® тариаг тариурын соруураар аажмаар соруулна.




3С

Бэлтгэл ажлыг дуусгах

Тариурыг зөөлөн товшиж эсвэл няслаад, илүүдэл хий, бөмбөлгийг арилгахын тулд тариурын соруурыг түлхэж/татна уу.

Тариурт 1.0 мл HEPCLUDEX® тариаг соруулахын тулд та тариурын соруурыг 1.0 мл тэмдэглэгээг өнгөртөл татах хэрэгтэй. Шилнээс зүү, тариурыг болгоомжтой салгана уу.




3D

Зүүг сольж хаях

Тариураас урт зүүг салгаж, бусдад гэмтэл учруулахгүйн тулд зүүг зориулалтын газар хаяна уу.

Чухал! Хуванцар тагийг зүүнд буцааж хийж болохгүй.




3Е

Тарихаар зүүг холбох

Тариурт богино зүүг оруулна.

Чухал! Хатгасан зүүг цагийн зүүний дагуу эргүүлэнгээ чанга оруулахын тулд доош нь бага зэрэг түлхэнэ үү.

Хуванцар тагийг сугалж авна уу.




3F

Тарих газрыг сонгох

Сүүлийн тарьсан газраас өөр газрыг сонгоно уу. Спирттэй шинэ хөвөнгөөр тарих газрыг цэвэрлэнэ. Төв хэсгээс нь эхлээд дарж, тойрог хөдөлгөөнөөр гадагш цэвэрлэнэ.


Чухал! Тухайн газрыг өрөөний температурт хатаана.



3G

Тарих газрыг бэлтгэх

Тарих газрын эргэн тойрны хэсэг арьсыг чимхэж барина.



3H

HEPCLUDEX® тариаг тарих

Арьсанд 45 градусын өнцгөөр хатгана. Зүүг ихэнх хэсгийг нь далд ортол оруулах хэрэгтэй.

HEPCLUDEX® тариаг тарихын тулд тариурын соруурыг доош нь тултал түлхэнэ. Арьснаас зүүг салгаж авна.

Тариураас урт зүүг салгаад, бусдад гэмтэл учруулахгүйн тулд зүү, тариурыг зориулалтын газар хаяна уу (3D зургийг харна уу).